

**АЛБАН ХААГЧДЫН 2023 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 01 сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

|   | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил арга хэмжээ                                | Сургалтад хамрагдах хүний тоо | Эх үүсвэр |        | Давтамж   | Биелэлт   |
|---|---|-------------------------------|-----------|--------|-----------|---|
|   |   |                               | Дотоод    | Гадаад |           |   |
| 1 | Шинээр ажилд орсон албан хаагчдад зориулсан танилцуулах сургалт                       | Шинэ ажилтнууд                | +         |        | тухай бүр | Шинээр ажилд орсон 15 албан хаагчид танилцуулах сургалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан. Шинээр ажилд орсон найруулагч Ц.Баярсайхан, Тасалбар шалгач Ю.Хулан, О.Түвшинжаргал, морин хуур хөгжимчин О.Цэрэнчимэд, А.Баярмаа, А.Мөнгөншагай дизайнер А.Ананд, тайзны туслах ажилтан Ц.Ариунбуйр, Их хуур хөгжимчин Б.Бат-Үндрах, Гэрэлтүүлэгч Д.Батмөнх, Дууны багш Д.Түвшинцогт, нярав Ч.Байгальмаа нарт байгууллагын дотоодод мөрдөгддөг дүрэм журам, байгууллагын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогийн талаар танилцуулах сургалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан.  |
| 2 | Театрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм журмын шинчлэл, өөрчлөлтийн тухай сургалт | Бүх албан хаагчид             | +         |        | 2 удаа    | Байгууллагын үйл ажиллагааны дотоодод мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журамд орсон өөрчлөлтийн талаар сургалтыг Хүний нөөцийн менежер Л.Одгэрэл 6 сарын 15-ны өдөр зохион байгуулж ажиллалаа. Тус сургалтанд жил бүр тус байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Иргээдийн хурлын тогтоо, Нийслэлийн Засаг даргын захирамж болон Улаанбаатар театрын дүрэм, театрын дотоод ажлын хэрэгцээнд зориулан баталсан журмуудын жагсаалт, мэдээллийн санг баяжуулсан талаарх мэдээллийг хүргэв. Тэдгээрээс онцлон театрын даргын тушаалаар шинчлэн баталсан байгууллагын дотоод журам, цалин хөлслний журам зэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн. Тус сургалтанд 45 албан хаагч хамрагдсан. Мөн Хедөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн, хуулийн зөвлөх Б.Бүрэнжаргал 2023 оны 10 дугаар сарын 23,25-ны өдрүүдэд нийт албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, хөдөлмөрийн тухай хууль, УБ театрын Ёс зүйн дүрэм, УБ театрын дотоод журам, Ёс зүйн хэм хэмжээнд зориулсан 2 удаагийн дэлгэрэнгүй сургалтыг анги тус бүрээр хувааж, танхимаар зохион байгуулсан. Тус сургалтад 56 албан хаагч хамрагдсан байна. |
| 3 | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга дэг журмын сургалт                              | Бүх албан хаагчид             | +         |        | 2 удаа    | 2023 оны “Улаанбаатар театрын албан хаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөө”-нд тусгагдсан “Байгууллагын үйлчилгээний соёл, албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр дүүргийн албан бус Насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулж, 38 албан хаагчийг хамруулсан. Театрын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын ёс зүй, дотоод уур амьсгал, хоорондын харилцаа, ажлын байрны сахилга бат-дэг журам, архидан согтууралт, ялгаварлан гадуурхалт, бэлгийн болон ажлын байрны дарамтыг үл тэвчих зэрэг асуудлуудад тулгуурласан ажлуудыг зохион байгуулж, албан хаагчдад анхааруулга санамжийг тухай бүр өгч, мэдээллийг самбарт байршуулан хяналт тавьж ажилласан. Тайлангийн хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга батын зөрчил гаргаж, ажлын байранд архидан согтуурсан зөрчил гаралагүй.  |

|   |   |                                      |   |                        |   |   |
|---|---|--------------------------------------|---|------------------------|---|---|
| 4 | Бакалавр, магистр, докторын зэрэг авах чиглэлээр мэргэжлийн чиглэлийн сургуульд элсүүлэх, суралцах нөхцөлөөр хангах | 4                                    | + |                        | 4 | Бакалавр, магистр, докторын чиглэлээр мэргэжлийн сургуульд элсэн суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцлийг хангаж, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажилласан. Эвэр бүрээ хөгжимчин Б.Баасансүрэн Соёл урлагийн их сургуульд докторын, морин хуур хөгжимчин Т.Санжаажамц Соёл урлагийн их сургуульд магистрын, ятга хөгжимчин Э.Намуундарь Соёл урлагийн их сургуульд магистрын зэрэг горилооор суралцаж байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргалыг "ХАБЭА" ХХК-ийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан.   |
| 5 | Удирдах дээд байгууллагуудаас зарласан танхимын болон цахим сургалтанд албан хаагчдыг хамруулах                     | Заасан тоогоор хамруулах албан хаагч | + | тухай бүр              |   | Dotood ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Цолмончимэгийг 6 удаагийн танхимын, 3 удаагийн цахим чадавхижуулах сургалтад хамруулсан. Мөн нягтлан бодогч, нярав нар 3 удаагийн цахим, 2 удаагийн танхимын, захиргааны ахлах мэргэжилтэн Б.Түмэндэлгэр, хүний нөөцийн менежер Л.Одгэрэл нар танхимын 6, цахим 8, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргал мэргэшүүлэх 1, танхимын 2, цахим 2, нярав Ч.Байгалмаа мэргэшүүлэх 1, цахим 2, Ерөнхий нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг, нягтлан бодогч Д.Дэлхийцэцэг нар танхимын 4, цахим 4 удаагийн сургалтад хамрагдсан. Мөн Төрийн Албаны зөвлөлөөс зохион байгуулдаг вебинаар сургалтад албан хаагчдаа тогтмол хамруулж хэвшсэн.  |
| 6 | Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт   | 6                                    | + | Шаардлагатай ажилтанд  |   | Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын журам"-ын 2.4 дэх хэсэгт заасны дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшлийн "Тэргүүлэх" зэрэгтэй ажилтан бэлтгэх, 8 багц цагийн сургалт 2023 оны 06 дугаар сарын 05-23-нд зохион байгууллагдсан сургалтанд хамрагдаж "Тэргүүлэх" зэргийн болзول хангасан. Архивын ерөнхий газрын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/55 тоот тушаалаар Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ Архив, албан хэрэг хөтлөлтийн Мэргэшлийн Тэргүүлэх зэрэг авсан. 09 сарын 28-ны өдөр "Архив албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй "EDOC системийн ашиглалт" арга зүй сургалтад 4 албан хаагч, 10 сарын 18-ны өдөр "Төрийн байгуулалагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй" сургалтад 2 албан хаагч хамруулж ажилласан. |
| 7 | Оффисын хэрэглээний программ ашиглалтыг сайжруулах сургалт  | 4                                    | + | Шаардлага тай ажилтанд |   | Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан хэрэглээний программын анхан шатны сургалтад 4 уран бүтээлчийг хамруулж ажилласан.  |
| 8 | Элдэв донтолт болон түүнээс гарах арга замууд, ажлын байран дахь эрүүл зөв хооллолт                                 | Бүх албан хаагчид                    | + | 2 удаа                 |   | 2023 оны 10 дугаар сард Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран зохион байгуулсан "Эрүүл амьдарцгаая" аяны хүрээнд ажлын байран дахь зөв хооллолт, стрессгүй ажлын байр зэрэг сургалтыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нийт албан хаагдад зориулан зохион байгуулж ажилласан.   |
| 9 | Гамшигаас хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга зүйн сургалт  | Бүх албан хаагчид                    | + |                        | 2 | ХАБЭА-н мэргэжилтэн ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлагыг хангуулж, үйлдвэрлэлийн осолгүй ажиллаж, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг хөгжим анги, дуу анги, бүхжиг анги, захиргааг анги, тайз ангиийн ажилчдад байнга өгч, зааварчилгааны дэвтэр дээр байнга гарын үсэг зуруулж, ажиллаж хэвшсэн. Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осол гараагүй. Улаанбаатар театр шинээр Бөмбөгөөр театртай болсонтой холбогдуулж уг театрт ажиллах Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, байнга хангуулж ажиллаж байна. Ажлын байранд эрсдлийн анхан шатны үнэлгээ хийж шаардлагатай зүйлсийг засаж янзалж албан шаардлага хүргүүлэв. эрсдэлтэй ажлын байранд ажилладаг 3 албан хаагчийг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэлтэй ажлын байранд ажиллах сургалтанд хамруулж сертификат олгов.                           |

Тайлан бичсэн:

Хүний нөөцийн менежер

Л.Одгэрэл

Хянасан :

Захиргааны ахлах мэргэжилтэн

902112051  
5097401 А ХНТ5524  
УЛААНБААТАР ХОТ

Б.Түмэндэлгэр